



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

12.07 - 12.11



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн гол индексүүд энэ долоо хоногийн дунд үе гэхэд түүхэн дээд ханшиндаа хүрсэн ч долоо хоногийн сүүлээр бууралт үзүүлснээр энэ долоо хоногт холимог үзүүлэлттэй хаагдлаа. Олон улсын зах зээл дээр газрын тосны (Brent) үнэ цар тахал эхэлснээс хойш анх удаа 50 ам.долларыг давсантай холбоотой S&P 500 индексийн сагсанд багтах эрчим хүчний салбар хамгийн их өсөлт үзүүлсэн бол мэдээлэл технологи болон үл хөдлөх хөрөнгийн салбар хамгийн их уналттай байлаа. Мөн энэ долоо хоногт Airbnb болон DoorDash компаниудын IPO амжилттай болсон байна. Энэхүү компаниудын хувьцааны арилжаа эхлэхэд ханш өссөн байна. Renaissance Capital-ийн үзэж байгаагаар, 2020 онд 2014 оноос хойших хамгийн их хэмжээтэй, хамгийн олон IPO хийгдэхээр байна.

Европ: Европын томоохон эдийн засгийн төвүүдэд коронавирусын тохиолдлын тоо нэмэгдэж байгаа, Brexit-ээс хойш баримтлагдах худалдааны хэлэлцээрийн тодорхойгүй байдалтай холбоотой энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Европын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэгч STOXX Europe 600 индекс 1.00%-аар, DAX индекс 1.39%-аар, CAC 40 индекс 1.81%-аар, FTSE MIB индекс 2.15%-аар тус тус буурсан бол FTSE 100 индекс тогтвортой байлаа.

Коронавирусын эсрэг вакцин болон АНУ-ын эдийн засгийг дэмжих хөтөлбөр нь Европын бондын зах зээл дээр өгөөж өсөх нөлөө үзүүлсэн ч Brexit-тэй холбоотой тодорхойгүй байдал Евробүсийн голлох бондуудын өгөөж энэ долоо хоногт бууралттай байхад нөлөөлжээ.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй байлаа. Nikkei 225 индекс 99 нэгжээр буюу 0.37%-аар бууран 26,751.24 нэгж хүрсэн нь оны эхэн үетэй харьцуулахад 12.7%-аар их байгаа юм. Харин Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг large-cap TOPIX болон TOPIX small индексүүд өсөлттэй хаагджээ.

Ерөнхий сайд Ёшихидэ Суга, Япон улсын засгийн газар коронавирусын цар тархалтын эдийн засагт үзүүлсэн нөлөөг арилгах зорилгоор 73.6 их наяд иений (706 тэрбум ам.доллар) гуравдах багцыг хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаагаа мэдэгдэв. Nikkei агентлагийн мэдээлснээр ойролцоогоор 52 их наяд иенийг эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг дэмжихэд зарцуулах бөгөөд үлдсэн дүн нь цар тахлыг зогсоох, гамшгийн менежментийг дэмжихэд чиглэгдэхээр байгаа юм.

БНХАУ: АНУ-ын хоёр том индекс БНХАУ-ын зарим компаниудыг жагсаалтаас хасаж АНУ болон БНХАУ-ын харилцаа хурцадмал байдалд хүрснээр БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Large-cap CSI 300 индекс 3.5%-аар Shanghai Composite индекс 2.8%-аар тус тус буурсан байна.

АНУ-ын Батлан хамгаалах яам БНХАУ-ын зарим компаниудыг БНХАУ-ын армитай холбоотойг тогтоосон тул S&P болон Dow Jones (S&P DJI) индексээс 21 компани хасагдсан байна. Энэхүү алхам нь өмнөх долоо хоногийн FTSE болон Russell индексийн гаргасан шийдвэртэй адил байгаа бөгөөд цаашид JP Morgan, MSCI, Nasdaq зэрэг бусад индекс тогтоогчид компаниудыг индексээс хасах эсэхээ хэлэлцэж байгаа юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,650.92	-0.21% ▼
Dow Jones	АНУ	30,046.37	-0.57% ▼
S&P 500	АНУ	3,663.46	-0.96% ▼
Nasdaq	АНУ	12,377.87	-0.69% ▼
S&P/TSX	Канад	17,548.92	0.16% ▲
FTSE 100	Их Британи	6,546.75	-0.05% ▼
S&P/ASX 200	Австрали	6,642.60	0.13% ▲
Nikkei 225	Япон	26,652.52	-0.37% ▼
Hang Seng	Хонг Конг	26,505.87	-1.23% ▼

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	3.36%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.12%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	2.98%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	0.93%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.06%
DBM' 2023	USD	7.250%	4.23%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	9.83%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	3.69%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.159	0.01 ▲
Libor 3M	0.217	-0.01 ▼
Libor 6M	0.249	-0.01 ▼
Libor 1YR	0.336	0.00 ▼
US 2YR Bond	0.121	-0.03 ▼
US 3YR Bond	0.177	-0.03 ▼
US 5YR Bond	0.364	-0.05 ▼
US 10YR Bond	0.893	-0.06 ▼

Валютын ханш	2020.12.11	Өөрчлөлт
USD	2,849.65	0.01% ▲
CNY	435.86	-0.06% ▼
EUR	3,456.63	-0.15% ▼
RUB	38.90	1.41% ▲
KRW	2.61	-0.76% ▼
JPY	27.38	-0.15% ▼
CAD	2,237.21	0.98% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,839.85	0.05% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	23.95	-0.97% ▼
Зэс	USD/lb.	352.80	0.10% ▲
Нүүрс	USD/MT	81.15	7.98% ▲
WTI газрын тос	USD/bbl.	46.57	0.67% ▲
Brent газрын тос	USD/bbl.	49.97	1.46% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.X	2.40%
Бодлогын хүү	2020.X	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.X	7.67%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.X	10.65%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.X	3.83%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.X	16.82%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.X	10.47%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 49 компанийн 814.7 сая төгрөгийн 5,871,569 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монинжбар” /MSE: MIB/ компанийн хувьцаа 15.00%-аар буую хамгийн ихээр өсөж 92.00 төгрөг хүрч хаагдсан бол “Хар тарвагатай” /MSE: TVT/ компанийн хувьцаа 16.07%-аар буурч 4,000.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 1.0 сая төгрөгийн 10 ширхэг үнэт цаас арилжаалагдав.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

12-р сарын 11-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,611.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,650.92 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.21%-аар буурсан байна.



Зах зээлийн тойм		Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн		815.7
Зах зээлийн үнэлгээ		2,611,266.4

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,650.92	-0.21% ▼
MSE I индекс	8,232.20	0.64% ▲
MSE II индекс	7,334.88	0.12% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Женко тур бюро	4,702,812	446,767,140
Ард санхүүгийн нэгдэл	178,095	246,259,396
Эрдэнэс сольюшинс	56,300	24,210,000
АПУ	38,235	22,043,708
Таван толгой	2,085	12,602,225

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монинжбар	92.00	15.00% ▲
Баянтээг	24,440.00	14.96% ▲
Түшиг уул	940.00	14.63% ▲
Могойн гол	7,050.00	13.71% ▲
БиДиСек	900.00	13.71% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Хар тарвагатай	4,000.00	-16.07% ▼
Тахь-ко	12,330.00	-14.97% ▼
Хөвсгөл алтан дуулга	601.96	-8.65% ▼
Багануур	1,000.00	-7.32% ▼
Оллоо	43.18	-6.13% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК		Дүн (төг)
БиДиСек		934,985,855
Ард Секюритиз		518,553,173
Алекс Капитал		30,238,747
Гацуурт Трейд		24,241,500
Эс Жи Капитал		24,210,000

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	581.50	618,821.57
Таван толгой	6,150.00	323,890.98
МИК холдинг	11,900.00	246,440.91
Инвескор ББСБ	2,913.00	208,943.43
Говь	190.00	148,221.38

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	10	1,007,060	100,020	101,000	52	17%

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Борнуур” /MSE: BOR/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон ээлжит бус хурал 12-р сарын 23-нд болно.

“Борнуур” /MSE: BOR/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 11-р сарын 25-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн боловч хурлын ирц бүрдээгүй хойшилсон тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хойшлуулан 2020 оны 12-р сарын 23-ны өдөр Борнуур сумын Соёлын төвд зохион байгуулахаар боллоо.

Хурлын бүртгэлийн өдөр: 2020 оны 11-р сарын 09-ний өдөр

Хурал хуралдах огноо: 2020 оны 12 сарын 23-ны өдөр

Хурал эхлэх цаг: 11:00 цаг

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн санхүү үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
3. Ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр
4. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох

Холбоо барих утас: 88222323, 89114474

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК-ийн нийт гаргасан хувьцааг бүртгэлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12-р сарын 9-ний өдрийн ээлжит хурлаар “Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК-ийн Канад Улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй 263,885,433 ширхэг хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэхээр шийдвэрлэлээ. Хувьцааг нэмж бүртгэснээр Монгол болон Канад Улсын иргэн, аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн “Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК-ийн хувьцааг Торонтогийн бирж болон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан чөлөөтэй арилжаалах нөхцөл бүрдэж байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Блюскай секьюритиз ҮЦК” /MSE: BSK/ ХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүллээ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 12-р сарын 7-ны өдрийн А/83 тоот тушаалаар “Блюскай секьюритиз ҮЦК” /MSE: BSK/ ХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлэхээр боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК нь Улаан тусгай зөвшөөрлийн талбайг 100% эзэмшин, Хөндий Алтны Дүүрэгт байр сууриа бэхжүүлэв.

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Лидер Эксплорэйшн ХХК-ийн 49%-ийг худалдан авч, Баян Хөндий Алтны ордтой залгаа орших Улаан тусгай зөвшөөрлийн талбайг 100% эзэмших болсныг мэдээлсэн байна.

Онцлох мэдээлэл:

- Улаан нь Хөндий дүүрэгт орших хэд хэдэн порфир, эпитермаль хэтийн төлөв бүхий бүсүүдийн нэг юм.
- Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь литокапын суурь доорх элэгдэлд орсон порфирын системтэй уялдан гидротермийн томоохон хувирлын системийг агуулдаг. Үүнд:
 1. Филлитийн (Кварц-серицит-пирит) хүчтэй хувирсан 3 км-ийн диаметр бүхий талбай
 2. Турмалин брекчтэй холбогдсон алт-зэсийн туслах эрдэсжилт
 3. Филлитийн бүстэй зэргэлдээ орших иллитийн хувирсан галт уулын кварцын судалд алт илэрсэн
- Компани хэд хэдэн эпитермаль алт болон порфирын зэсийн хэтийн төлөв бүхий талбайг агуулж буй Хөндий-Улаан хувирлын системийн дийлэнхийг багтаасан талбайг 100% эзэмшин, нэгтгэлээ.
- Баян Хөндий Алтны ордын зэргэлдээ орших эрдсийн хайгуулын тусгай зөвшөөрлийн байр сууриа бэхжүүлэв.
 1. Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь Баян Хөндий орд, Хар Морь болон Алтан Сум талбайн баруун талд зэргэлдээ оршдог
 2. Эрдэнэ Ресурсийн хэтийн төлөв бүхий Хөндий Алтны Дүүргийн талбайг 17,004 га (170 км²) болгон өргөжүүлээ.
- sХайгуул хязгаарлагдмал хийгдсэн боловч геологийн хувьд өндөр ач холбогдолтой
 1. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд хязгаарлагдмал өрөмдлөгийн хөтөлбөр, зураглал, дээжлэлт болон геофизикийн судалгаа хийгдсэн.
 2. Гадаргын дээжлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд 2021 оны 1-р улиралд өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Эх сурвалж: Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлахыг Засгийн газартаа үүрэг болголоо. Тус улс улаанбуудайн экспортоор дэлхийд тэргүүлдэг ч дотооддоо хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтоон барьж чадахгүй байгааг тэрбээр шүүмжилсэн байна. Улмаар дотоодын зах зээл дэх нөөцийн баталгаатай байдлыг хангахын тулд ирэх оны улаанбуудайн экспортын хэмжээг хязгаарлах санал гаргажээ. Үүний дараа дэлхийн зах зээлд улаанбуудайн үнэ өслөө. Пүрэв гарагийн байдлаар улаанбуудайн үнэ 0.17 хувиар өсөж, багц нь 584.25 ам.доллар болжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

ГЕГ: XI сарын байдлаар автобензиний импорт 20 хувиар буурч, 418 сая ам.доллар болсон

Оны эхний 11 сарын байдлаар автобензиний импорт үнийн дүнгээр 20 орчим хувиар, дизель түлшний импортын дүн 40 орчим хувиар буураад байна.

Харин автобензиний импортын биет хэмжээ өсжээ. Энэхүү өөрчлөлтөд автобензиний импортын дундаж үнэ өмнөх онд 602 ам.доллар байсан нь энэ оны 11 дүгээр сарын байдлаар 418 ам.доллар болж огцом буурсан нь нөлөөлжээ.

Дизель түлшний импортын хэмжээ өмнөх оныхоос 72 мянган тонноор буурсан байна. Хэдий тийм боловч импортын дүн буурсан гол шалтгаан нь автобензиний адилаар олон улсын зах зээл дэх үнэ огцом буурсантай холбон тайлбарлаж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

Ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах арга хэмжээ үргэлжилж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хүндрэлийн үед иргэдийн орлогыг хамгаалж, зээлийн дарамтыг бууруулах зорилгоор Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг 2021 оны 7-р сарын 1-ний өдрийг хүртэл хойшлуулах арга хэмжээг Монголбанк, Сангийн яам, МИК ОССК ХХК болон банкууд хамтран хэрэгжүүлж байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд банкууд орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг иргэдээс цахим хэлбэрээр авч эхэлсэн бөгөөд 2020 оны 12-р сарын 4-ний өдрийн байдлаар нийт 2.11 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 38,828 зээлдэгч хүсэлт гаргаснаас 1.87 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 33,929 зээлдэгчийн хүсэлтийг буюу 87 орчим хувийг нь шийдвэрлэж эргэн төлөлтийг хүү хуримтлуулахгүйгээр хойшлуулаад байна.

Иргэд өөрсдийн харилцагч банкандаа орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг цахим хэлбэрээр 2021 оны 1-р сарын 30-ны өдрийг дуустал гаргаж, шийдвэрлүүлэх боломжтой юм.

Эх сурвалж: Монголбанк

SICA: Хөл хорионы үед өрхийн орлого 40 хувиар буурсан дүн гарсан

"SICA" байгууллагаас Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэгт амьдардаг 401 өрхийг хамруулсан судалгааг 12 дугаар сарын 5-9-ний хооронд хийжээ.

"COVID-19" дотоодод тархахаас өмнө өрхийн дундаж орлого нэг сая 325 мянга 400 төгрөг байсан бол хөл хорио тогтоосноор орлого нь 796 мянга 100 төгрөг болж огцом буурчээ. Энэ хугацаанд сард 700,001 төгрөгөөс дээш орлоготой байсан өрхүүдийн эзлэх хувь буурч, 700 мянга хүртэлх орлогын бүлэгт эзлэх өрхүүдийн хувь нэмэгдсэн гэжээ. Энэ нь орлого сайтай өрхүүдийн санхүүгийн байдал муудаж, бага орлоготой хэсэг рүү шилжсэнийг харуулж байна.

Мөн өрхүүдийн 88.5 хувь нь гэнэтийн нөхцөл байдалд зориулсан хадгаламжгүй байсан гэж хариулжээ. "Өрхүүд цаашид ард иргэдэд мөнгөн тусламж бодитойгоор үзүүлэх, хөл хориог сулруулж уян хатан болгох талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хүсэж байна" гэж судлаачид дүгнэсэн байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

Цар тахлын үед тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний цахим борлуулалт азид эрс нэмэгдэв.

Энэ оны баярын улиралд бөөний худалдаанаас гадна тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний эрэлт Азид дээд түвшинд хүрч өсөөд байна.

Ялангуяа тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний цахим борлуулалт эрс нэмэгджээ. Тухайлбал: "Christie's"-ийн цахим борлуулалт энэ онд 200 хувиар өсөөд байгаа аж. Тус компани өнгөрсөн оны 11, 12-р сард тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний дөрвөн удаагийн цахим дуудлага худалдаа зохион байгуулж байжээ. Харин энэ онд эрэлт өндөр байгаа тул 12 удаагийн дуудлага худалдаа товллоод байна.

Харин "Sotheby's"-ийн хувьд борлуулалт нь өнгөрсөн оны мөн үеэс дөрөв дахин, жилийн дүнгээр тав дахин өсжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ханги боомтын нүүрсний экспорт хэвийн боллоо.

Дорноговь аймгийн нутагт орших Ханги боомтын нүүрс тээврийн жолоочийн "COVID-19"-ийн давтан шинжилгээний хариу "Сөрөг" гарсан байна. Ингэснээр түр зогсоогоод байсан боомтын үйл ажиллагаа баасан гарагаас хэвийн болсныг гаалиас мэдээллээ.

Монгол Улс оны эхнээс 12-р сарын 9-ний өдөр хүртэл нийт 27.3 сая тонн нүүрс экспортолсны 1.7 хувийг Ханги боомтоор гаргаад байна. БНХАУ-ын тал нүүрс тээврийн жолооч нарыг "COVID-19"-ийн шинжилгээнд хамруулахыг шаардаж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улс энэ талд нэлээд эрчимтэй арга хэмжээ авсан юм.

12-р сарын тавны байдлаар Гашуунсухайт-Цагаан хад чиглэлийн богинын тээврийн 6,569 жолоочийг PCR шинжилгээнд хамруулж, бүгд "Сөрөг" гэсэн хариу гарсан байна.

Үүнээс гадна Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн уртын тээврийн 7,000 гаруй жолоочийг шинжилгээнд хамруулж эхэлсэн талаар "Эрдэнэс Монгол" ХХК мэдээллээ.

Одоогоор "Гашуунсухайт авто зам" компанийн шалгах нэвтрүүлэх гурван цэг дээр шинжилгээ авч байгаа аж. Хөдөлгөөний ачаалал нэмэгдэж, дараалал 40 км-ээр уртассаныг "Эрдэнэс Монгол" ХХК мэдэгдэлдээ дурджээ.

Экспортын гол уурхайнуудыг эрсдэлгүй бүс болгох чиглэлд одоогоор нүүрсний экспортын 95 хувь, зэсийн экспортын 100 хувь, газрын тосны экспортын 100 хувь, төмрийн экспортын 90 хувь, жоншны экспортын 70 хувийг бүрэн хамгаалалтад авсан гэж Улсын онцгой комисс мэдээлсэн юм.

Одоогоор боомтуудын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. Цагаан нуур боомтын үйл ажиллагааг 12-р сарын нэгнээс эхлэн гарагийн зохицуулалттайгаар нээсэн юм. Зөвхөн нефтийн бүтээгдэхүүн оруулж ирж байгаа аж. Эрэнцав боомтын төмөр замын хөдөлгөөнийг мөн нефтийн бүтээгдэхүүн оруулах зорилгоор 12-р сарын 1-ээс нээгээд байна.

Харин Замын-Үүд боомтод Эрэн талдаа 50 жолооч 30 хоногийн хугацаатай байршуулж, Гаалийн хяналтын талбайгаас хилийн боомтын дундын бүсэд автомашин солилцох байдлаар тээврийн зохицуулалт хийх шаардлагыг БНХАУ-ын тал тавьсан юм. Энэ ажлыг зохион байгуулж байна. 12-р сарын 9-ний байдлаар Монголын талаас 18 жолооч энэхүү тээврийн ажлыг хийж байгааг Улсын онцгой комисс мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

БНХАУ, Австралийн харилцаа хурцдаж байгаа ч төмрийн хүдэрт хориг тавиагүй байна.

БНХАУ, Австралийн харилцаа улам хурцдаж байгаа ч БНХАУ-ын төмрийн хүдрийн эрэлт өссөөр байгаа тул Австралиас төмрийн хүдэр худалдан авсаар байна.

БНХАУ цар тахлын дараа эдийн засгаа сэргээхийн тулд дэд бүтцийн салбарт их хэмжээний хөрөнгө оруулж байгаа нь төмрийн хүдрийн эрэлт өсөхөд голлон нөлөөлж байгаа аж. Дэлхийн төмрийн хүдрийн хэрэглээний талаас илүүг Австрали улс нийлүүлдэг. Хэрэв БНХАУ Австралийн төмрийн хүдрийн импортыг хориглосон тохиолдолд төмрийн хүдрийн импорт нь одоогийнхоос 56 орчим хувь болж буурна гэж "Goldman Sachs" тооцоолсон байна.

БНХАУ-ын тогтоосон хязгаарлалтууд одоогоор Австралийн дотоодын нийт бүтээгдэхүүний 0.3 хувьд нөлөөлөөд байгаа аж. Харин БНХАУ төмрийн хүдрийн импортод хориг тавихад Австралийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт дараагийн нэг жилд хоёр нэгж хувиар буурна гэж "Goldman Sachs" тооцоолжээ.

Лхагва гарагийн байдлаар Далянийн Таваарын биржид төмрийн хүдрийн фьючерс үнэ тонн нь 923 юань болоод байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.